



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/1521

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн бүртгэлээс
барилга байгууламж хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн балансад бүртгэлтэй 7,205,923.00 (долоон сая хоёр зуун таван мянга есөн зуун хорин гурав) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 7,205,923.00 (долоон сая хоёр зуун таван мянга есөн зуун хорин гурав) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан гүний худгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга (дэд хурандаа Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

2. Акталж, данс бүртгэлээс хасах барилгыг нурааж буулгахад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулахыг Хяналт шалгалтын газар (С.Энхбаяр)-т үүрэг болгосугай.


3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР



1110206922



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

Д/А	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ
1	Гүний худаг	24	ш	1	7,205,923.00	7,205,923.00	7,205,923.00	-
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						7,205,923.00	7,205,923.00	-